

СУРЛАГЫН ХОЦРОГДЛЫГ АРИЛГАЖ БУЙ ЗӨВЛӨЛТИЙН НЭГЭН СУРГУУЛИЙН ТУРШЛАГААС

*Ц.Нарантуяа, Ц.Цэндсүрэн
Улсын багшийн дээд сургуулийн багш*

Бүх нийтийн дунд боловсролын тухай хуулийг биелүүлэх нь сурган хүмүүжүүлэгч хамт олон бүрийн ажлын үндсэн зорилт мөн. Нэг ч сурагчийг сургууль завсардуулахгүй байх, хүүхэд нэг бүрийг дунд боловсролтой болгож тэдэнд шинжлэх ухааны үндсэн мэдлэг, хөдөлмөрийн чадвар, дадлагыг эзэмшүүлэх, амьдралд байр сууриа олох, түүнийг идэвхитэй гардан байгуулагч, хувьсган өөрчлөгч болгоход бид бүх хүчээ чиглүүлэх ёстой. Энэхүү нарийн төвөгтэй зорилтыг зөвхөн сурган хүмүүжүүлэх ур чадварыг байнга боловсронгуй болгох замаар л шийдвэрлэж болно. Сүүлийн хэдэн жилийн туршид Их Луки дахь төмөр замын дотуур байртай 5 дугаар сургуулийн хамт олон сурлагын хоцрогдлыг арилгах асуудлаар нэлээд ажил зохиож байна. Энэ сургуульд суралцагчдын гуравны нэг нь жил бүр өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг тул энэ асуудлыг бүр ч их чухал гэж үздэг ажээ. Сурагчид хичээлийн жилийн туршид нэмэгдэн ирсээр байдаг бөгөөд эдгээр нь 12-15 насны хүүхдүүд юм. Тэдний дотор сурлага хичээлээ зөв зохион байгуулж чаддаггүй юм уу, эсвэл ер нь суралцах хүсэл сонирхолгүй хүүхдүүд цөөнгүй байдаг гэнэ. Зарим нь сахилга батын хангалтгүй дүнтэй, хүмүүжлийн хувьд доголдолтой, засаж залруулахад бэрхшээлтэй болсон байдаг. «Анхнаасаа эхлэн суралцах хүсэлгүй хүүхэд байдаггүй, байх ч ёсгүй» гэж В. А. Сухомлинский хэлсэн байдаг. Ингэхлээр тэд хүүхдүүд яагаад суралцах дур сонирхолгүй болдог, түүнийг хэрхэн давж туулах арга замыг эрж сурвалжлахаас л өөрийн ажлаа эхлэхээр шийдвэрлэсэн байна.

Суралцах хүсэлгүй болохын түгээмэл нэг шалтгаан бол нэг талаас өөрсдийн хүчинд итгэх итгэлээ алдах, нөгөө талаас сургууль дамжин шилжих явдал юм. Жишээлбэл, сурлага сахилгаар барагтайхан сурагч С. Володя 7 жилийн туршид 4 удаа сургууль сольж шинэ хамт олны дунд орж, янз бүрийн багш нарын шинэ шинэ шаардлагатай тулгарчээ. Ийм байдал нь суралцагчдад муугаар нөлөөлөн хэрэг зөрчилд оруулах, хичээл номондоо хойрго болж таслах зэрэг ихээхэн муу нөлөө үзүүлдэг гэж үзэцгээдэг. Тэгэхлээр ийм

сурагчидтай нөхөрсөг тайван харьцаж, тэдний сахилга бат, сурлага, хөдөлмөрийг нь тогтмол үнэлэн, сайн талыг нь дэмжин урамшуулахад анхаардаг гэнэ.

“Алдаж болзошгүй байлаа ч гэсэн өөдрөг сэтгэлээр хүнд хандаж байх хэрэгтэй” гэсэн А. С. Макаренкогийн үгийг манай багш нар ямагт санаж ажилладаг.

Сурагч нэг бүрийг сургаж хүмүүжүүлэх талаар багш нар маш чухал хариуцлага хүлээн, түүнийгээ зохих ёсоор ухамсарлаж, хичээлийн болоод хичээлийн бус цагаар сурагч нэг бүрийн хүч, бололцоонд тохируулан уйгагүй хөдөлмөрлөдөг байх нь чухал гэж тэд үздэг. Нэг ч хүүхдийг муу сургахгүй байх хамгийн гол, үр ашигтай арга нь тэднийг өөрсдийн хүчинд итгэн ажиллаж чаддаг болгох явдал юм. Тэд нарын ажлын гол зарчим бол хүүхдийн сэтгэл санаанаас айж тэвдэж, сандарсан байдлыг авч хаян, тэднийг өөрсдийнхөө бололцоонд итгэсэн, чөлөөтэй, тайван байлгахад чиглэгддэг ажээ. Хамгийн сул сурлагатай хүүхэд ч гэсэн хичээлээс хичээлд бага боловч амжилт гарган ахиж байгаагаа өөрөө ойлгон ухамсарлах нь чухал бөгөөд энэ нь багш, сурагчийн хооронд харилцан итгэлцсэн уур амьсгал тогтсон нөхцөлд л боломжтой юм.

Олон жилийн туршид тэр сургуулийн багш нар сурагчдын насны онцлог болоод сэтгэл зүйг гүн гүнзгий судалж байна. В.А.Сухомлинскийн “Хамт олны ухаалаг удирдлага”, “Хүүхдүүдэд сэтгэл зүрхээ өгье”, “Иргэн төрж хүмүүжих нь” хэмээх бүтээлүүд ба В.А.Крутецкийн “Сурган хүмүүжүүлэх сэтгэл зүй” номоор багш нарын дунд сурган хүмүүжүүлэх уншлага зохиосон нь ихээхэн үр дүнтэй болжээ.

Сурган хүмүүжүүлэгчид ажиглалт хийн, өдөр тутам тэмдэглэл хөтлөн түүндээ хүүхдийн сахилга бат, сурлага, олон нийтийн ажилд оролдож байгаа байдал, багш, хамт олондоо хандах хандлагад гарч байгаа өөрчлөлтүүдийг тусгадаг. Багш нар сурлагаар хоцрогсдод тусгай карт нээн, түүндээ чухам ямар хичээлд ямар сэдвээр хэрхэн хоцорч байгааг тэмдэглэж цаашдаа хоцрогсодтой хичээлийн болон хичээлийн бус цагаар хэрхэн

ажиллах төлөвлөгөөг боловсруулдаг. Хэрэв ийнхүү байнга анхаарч үнэн сэтгэлээсээ ажиллавал, хоцрогсдын ихэнх нь хичээл сурлагадаа идэвхтэй, дур сонирхолтой болж ирдэг гэнэ. Сурлагаар хоцрогсдод “Чи ирэх жил улирна” гэж хичээлийн жилийн дундуур урьдаас урам зоригийг нь хугалдаг муу зуршил байсаар байгаа бөгөөд ингэснээрээ тухайн хүүхэд нэгэнт улирахаас хойш яахав гээд сэтгэл санаагаар унан, хичээлдээ бүр ч сонирхолгүй болно.

Тэр сургуулийн ихэнх багш нар сурагч нэг бүрийн хувь заяаны төлөө хүлээх хариуцлагаа бүрэн ухамсарладаг ажээ. Тэдний сургууль дээр нэг ийм явдал болжээ. Хичээлийн жилийн сүүлчээр насанд хүрээгүйчүүдийн хэрэг эрхлэх газраас явуулсан нэгэн сурагчийг хүлээн авчээ. Тэр бол бүх хичээлдээ муу дүн авдаг, огт сонирхолгүй, нийгмийн хэв журам зөрчих хандлагатай сурагч байв. Багш бүр түүнтэй ярилцан, уг сурагчийн бололцоо нөхцөлтэй танилцан судалж, улмаар зуны амралтын үед түүнтэй ганцаарчилсан хичээл хийжээ. Үүний гол нь тэр сурагч дараагийн ангидаа дэвшин суралцаж болохоор байна гэдгийг л түүнд ойлгуулж чадсан хэрэг. Тэгээд энэ сурагчтай маш нарийн шаргуу ажиллажээ. Ер нь энэ сурагчийн сурлагын хувь заяаны төлөө “жинхэнэ тулалдаан” болж байна гэж хэлж болох юм. Одоогоор эцсийн үр дүнг гаргахад эрт байна, гэхдээ хамгийн гол нь хэдийгээр маш удаавтар боловч уг сурагчаас сургууль, сурлага хичээлдээ нааштайгаар хандах болж байна гэж захирал нь бичсэн байна. Сурлагаар хоцрогсодтой ганцаарчилан, тодорхой ажиллаж нааштай үр дүнд хүрч байгаа талаар олон жишээ дурдаж болно.

Псков мужийн Дно хотоос В. Николайг хамгийн хэцүү сурагчийн нэг гэж тэр сургуулийн IX ангид шилжүүлжээ. Сайн бодож боловсруулсан ганцаарчилсан ажиллагааны үр дүнд энэ сурагчийн сурлага, сахилга батад нэлээд өөрчлөлт гарчээ. Энэ залуу сургуулиа амжилттай төгсөөд, дараа нь Ленинградын төмөр замын дээд сургуулийг төгсөөд одоо БАМ-д хэсгийн даргаар ажиллаж байна гэнэ. Г. Александр бас л “хэцүү” хүний нэг байсан бөгөөд тэр сургуулийн VI ангид ирсэн юм. Түүнтэй ажиллахад хэдийгээр маш бэрхшээлтэй байсан боловч тэр сургуулийнхны уйгагүй хөдөлмөр талаар өнгөрсөнгүй. Александр дунд сургууль, дараа нь техник мэргэжлийн сургуулийг төгсөөд одоо заводод ажиллаж байгаа агаад коммунист хөдөлмөрийн гавшгайч болжээ.

Сурлага хичээлдээ муу байхын хамгийн нэг газар авсан шалтгаан бол хөдөлмөрлөж ажиллаж чадахгүй байгаа явдал юм. Үүний нягт уялдаа

холбоог тодорхойлон, В.А. Сухомлинский хэлэхдээ: “Хөдөлмөрлөж чадахгүйгээр болж, дур сонирхол төрдөггүй дур сонирхолгүйгээс болж залуу хойрго болно. Энэ дутагдал нь цаашид улам бүр даамжрах бөгөөд түүнийг арилгахад нэн бэрх” гэжээ. Иймэрхүү тохиолдолд тэднийхэн дараах зорилтыг тавьдаг байна. Тухайлбал сурагчийг хөдөлмөрлөж сургах, сурлага хөдөлмөрөө аль болохоор үр ашигтайгаар зохион байгуулж чадахуйц дадал, заншилтай болгохыг зорьдог. Гэвч энэ зорилтыг амжилттай шийдвэрлэх эн тэргүүний угтвар нөхцөл нь чухам тийм дадал, заншлыг бий болгож чадахуйц багш сурган хүмүүжүүлэгчид хэрэгтэй байлаа.

Бүх багш нарын семинарыг зохион байгуулан “Хичээл дээр сурагч нэг бүрт тохируулан ажиллах нь”, “Сурлагын явцад сурагчдын сэтгэл зүйн хоцрогдлыг даван туулах нь” зэрэг сэдвийг авч хэлэлцжээ. Багш нарын зөвлөлгөөнөөр “Оюун санааны үйл ажиллагааг зөвөөр залан удирдаж чаддаг болох нь сургалтын зайлшгүй нөхцөл мөн”, “Сурагчдыг бие даан номтой ажиллуулж сургах нь” зэрэг сэдвүүдийг авч хэлэлцжээ. Хуримтлуулсан туршлагынхаа талаар “Сурагч, багшийн шинжлэх ухааны үндэслэлтэй хөдөлмөр зохион байгуулалт”, “Сурагчийн танин мэдэхүйн үйл ажиллагааны идэвхжил”, “Сурагчид өөрөө өөрийгөө хүмүүжүүлэх нь”, “Сурлага хөдөлмөрт хариуцлагатай хандаж сургах нь” зэрэг асуудлыг онол практикийн бага хурлууд дээр авч хэлэлцжээ.

Энэ сургуулийн хамт олон хүүхдийг муу суралцаж байна гэж шийтгэхдээ бус харин суралцаж чаддаг болгож сургах нь чухал гэж үздэг байна. Математикийн багш Ы. В. Павловагийн туршлагаас үзэхэд, тэрээр хичээл бүр дээр сурагчдад оюуны хөдөлмөрийн дадлага олгоход анхаардаг байна. Энэ багш сурлагаар хоцрогсдод тусгай санамж материал бэлтгэн, түүнд гэрийн даалгавраа яаж хийх, хяналтын ажил болоод геометрийн бодлогыг яаж бодох зэрэг асуудлыг тусгай өгдөг. Сурагчдын мэдлэгийг бататгахын тулд энэхүү санамжийн дагуу хийсэн зааварчилгааны картуудыг тарааж өгдөг байна. Мөн янз бүрийн сэдвээр хоцрогсодтой тусгай хичээл явуулан, тэдний оюуны хөдөлмөрийн арга зүйг хөгжүүлэхэд тусалдаг. Жишээлбэл, хичээлд яаж анхаарлаа төвлөрүүлэх вэ? зэрэг олон сэдвүүд хамаарагдана. Эдгээр хичээлүүдээр энэ багш бүхэл бүтэн хөтөлбөр бэлтгэжээ. Тухайлбал, сурлагаар хоцрогсдын ар гэрээр 2-оос доошгүй удаа орох, сурлагаар хоцрогсдод ганцаарчилсан даалгавар өгч түүний гүйцэтгэлийг заавал шалгах, ийм сурагчдыг ямар ч тохиолдолд арын ширээнүүдэд

суулгахгүй байх, ялихгүй ч атугай сурлагын ахиц, идэвх санаачилгыг заавал хөхүүлэн дэмжиж байх, сурлагаар хоцрогсдыг хамгийн гол нь хичээллүүлж сургахыг ямагт анхаарах, улирал тутам ядаж 6-10 удаа асуухыг чармайх зэрэг олон асуудал орсон байна. Н.В.Павлова зарим сурагчид яагаад математикийн хичээлд дур сонирхолгүй байдгийн шалтгааныг судалж байна. Жишээлбэл, VII ангийнханд дараах асуултууд бүхий анкет тараажээ. “Чамайг, сайн сурахад юу саад болоод байна вэ? Ямар бэрхшээл юун дээр тохиолдож байна вэ? Ямар тусламжийг, хэнээс авмаар байна вэ? Математикийн ямар даалгавар хийх дургүй вэ? Чи ямар мэргэжилтэй болохыг хүсдэг вэ? гэх мэт.

Сурагчдыг математикийн хичээлд дур сонирхолтой болгохын тулд сайн тоологчийн уралдаан, математикийн үдэшлэг олимпиад, математикийн “маргаан” зохиох зэргээр энэ багш тодорхой чиглэл бүхий ихээхэн хэмжээний ажлуудыг хичээлийн бус цагаар зохиож байна. Иймэрхүү тодорхой ажлууд нь зохих үр дүнгээ өгч, Н.В.Павловатын зааж байгаа хичээлээр сүүлийн 5 жилд улирсан сурагч гарсангүй. Октябрийн төмөр замын сургуулиудын математикийн багш нарын онол практикийн бага хурал дээр сурагчдын сурлагын чанарыг сайжруулах, тэдний сэтгэн бодох чадварыг дээшлүүлэхэд чиглүүлж явуулдаг арга барилын талаар Н.В.Павлова илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна.

Тэр сургууль дээр сурагчдыг биеийн хөдөлмөрт оролцуулах талаар их ажил зохиогдож байна. Сурагчид сургууль дээрх уран дархны газруудад дуртайяа хөдөлмөрлөн, үйлчилгээний ажилд болон ургац хураалтад оролцох хөдөлмөрийн улиралд тэд хичээнгүйлэн ажиллацгаадаг. Биеийн хөдөлмөрт сайн оролцож байгаа сурлагаар хоцрогсдыг сургууль, гэр бүлийн хүрээнд урамшуулан магтаж тэдгээрийн ололт, амжилтыг шугаман жагсаал, хөдөлмөрийн баярын үед зориуд сайшаан тэмдэглэдэг байна. Энэ нь сурлагаар хоцрогсдод өөрийнхөө хүч бололцоонд итгэх итгэлийг төрүүлэн, тэр нь улмаар сурлага, хичээлд нь сайнаар нөлөөлж байна гэнэ. Хамгийн их бэрхшээл учруулж байгаа сурагчид бол хичээлдээ огт сонирхолгүй, сахилга батгүй, хичээл тасалдаг (нэг үгээр хэлэхэд) “хэнэггүй” хүүхдүүд байдаг. Эдгээр нь гол төлөв VII-VIII ангийн сурагчид байдаг. Суралцах дургүйн учраас тэд ажиллах хүсэлтэй гэж тайлбарлана. Гэвч тэд ажил хөдөлмөр хийж эхлэх болоогүй байгаа нь ойлгомжтой. Тийм сурагчид нь сурлага хичээлийн ямар ч бүтээлч арга барилгүй, оюуны хөдөлмөр

урт удаан хугацаагаар хийх тэвчээр хатуужилгүй байдаг бөгөөд тэднийг ухамсарлан сэтгэх идэвхтэй үйл ажиллагаанд сургахын тулд тэр сургуулийн багш нар хичээлийн туршид эдгээр хүүхдүүдэд ажиллах хамгийн таатай зохион байгуулалтын болон сэтгэл зүйн нөхцөл бүрдүүлэхийг хичээдэг.

Ийм сурагчидтай хэрхэн ажилладаг талаар орос хэл, утга зохиолын багш Т.П.Макаровагийн ажлын туршлагаас танилцуулъя. Бүх хичээлийн туршид сурлагаар хоцрогсдыг идэвхтэй ажиллуулах, ганцаарчилсан даалгаврын карт өгч ажиллуулах, сурагчдад хэсэгчлэн даалгаврыг өгч тухай бүр шалгаж, тусалж зөвлөлгөө өгдөг. Материалыг давтах, зөв бичих дүрмийн алдааг засах, олж авсан сайн дадал заншлаа бататгах, уйгагүй ажиллах, гэрийн даалгаврыг шалгахад онцгой анхаардаг байна. Ер нь сурлагаар хоцрогсдыг өөрийн эрхгүй ажиллахуйц нөхцөл бүрдүүлдэг байна. Т.П.Макарова нь багш, сурагчийн хоорондын харилцааны эцсийн үр дүнг аль болохоор хурдан тогтоох, машингүй программчлалын арга, сурлагын карт, тооцооллын карт зэргийг ашиглаж байна. Сурагчдын хэлний сонирхлыг дээшлүүлэхийн тулд хичээлд “хөгжөөнтэй радио” нэвтрүүлэг, хэл зүйн материалуудыг ашигладаг. Сайн сурах хэрэгтэй гэж уриалаад байснаар олигтой үр дүнд хүрдэггүй юм байна гэдэгт тэдний сургуулийн удирдлага, багш нар итгэсэн ажээ. Сурагчдад нэгдсэн шаардлага тавихын тулд сурлагаар хоцорч буй хүүхдэд хичээлээс гадуур явуулах арга хэмжээний системийг боловсруулж байдаг тийм багш нарын зөвлөлгөөнийг зохион явуулдаг. Сурах сонирхолгүй сурагчдын мэдлэгийн хүрээ маш явцуу байдаг. Тэд бараг юм уншдаггүй. Тийм сурагчдад унших явдлыг хэвшил, тэдний хэрэгцээ болгохыг гол зорилтоо гэж үздэг байна. Уншлагыг багш, хүмүүжүүлэгч, номын санч нар удирдан явуулах ёстой. IV-VIII ангийн сурагч бүр ангиас гадуур уншлагын тэмдэглэлийн дэвтэртэй байж, биеэ дааж уншиж тэмдэглэлээ хүмүүжүүлэгчийн хяналтын дор хөтөлж номын санд уншсан номоороо долоо хоног бүр ярилцлага явуулдаг. Хангалтгүй дутуу уншсан сурагчидтай эвлэлийн хурал, Ленинч шүүлэг дээр маш нарийн ярилцдаг. Сурагчдаар сонин сэтгүүл уншуулж сургадаг. Өгүүллийг шүүн хэлэлцэх ажлыг бүр II ангиас нь эхэлдэг. Хүүхдүүдийг уншиж сургах, тэдний мэдлэгийн хүрээг нэмэгдүүлэх ажлыг түүхийн багш Т.П.Большакова үр дүнтэй явуулдаг. Энэ багш сурагчдаар түүхийн хичээлээр шинжлэх ухааны ном зохиолоос уншуулж, түүгээрээ ангидаа мэдээлэл хийлгэдэг. Энэ ажлыг урамшуулахаас биш түүнд дүн тавьдаггүй. Ном

зохиол унших, нэмэлт даалгаврууд янз бүрээр өөрчлөгдөж байдаг. Сурагчид өгөгдсөн сэдвээр биеэ дааж материал бэлдэх, тодорхой сэдвүүдээр альбом хийх, нутаг орны сонин хачин юмс цуглуулах зэрэг ажлыг хийдэг.

IX-X ангийн зарим сурагчид бол “Хэзээд л ажил хийхээс хойш сураад яах юм бэ?” “Дээд сургуульд орохгүй”, “Ажилчид бол инженерээс дутахгүй цалин авдаг шүү дээ” гэх бодолтой байдаг. Сурагчдад сурах мэдэх нь хүн бүрийн зайлшгүй хэрэгцээ гэдгийг ухамсарлуулан тэдэнд сурахсан гэсэн хүсэл тэмүүлэл бий болгохыг л бид зорих ёстой. Сурагч бүрээр сурахын нийгмийн ач холбогдлыг ойлгуулахыг бид хичээдэг гэж захирал нь бичсэн байна.

Сургууль дээр түүхийн хичээлээр “Агуу их Октябрийн социалист хувьсгал”, математикийн хичээлээр “Математик ба үйлдвэрлэл” гэх мэтчилэнгийн сэдвүүдээр онолын бага хурлууд явагддаг. Сонгон суралцах курс ба дугуйлангуудад хичээллэдэг сурагчдын бүтээлийн үзэсгэлэнг зохион байгуулдаг байна. Сурлага хичээлдээ зөв хандах явдал бол сургууль, ангийн хамт олны өмнө хариуцлагаа ухаарахтай холбоотой.

Долоо хоног бүр нийтийн шугам жагсаал дээр ангиудын сурлагын амжилтын тайланг сонсдог. Сурах хүсэлгүй сурагчдыг бүлгэмийн зөвлөл, эвлэлийн хороо, сурлагын комиссын хуралд урьж оролцуулдаг. Тэдэнд сурах мэдэх нь зайлшгүй хэрэгцээ гэдгийг ойлгуулахын тулд “Хүнд яагаад мэдлэг хэрэгтэй вэ?”, “Бие хүний бүх талын хөгжил гэж юу вэ?” гэсэн сэдвүүдээр явуулсан маргаанууд ихээхэн сонирхолтой болжээ. Ийм маргаанд үйлдвэрийн тэргүүний ажилчид оролцдог байна. Тэд орчин үеийн ажилчин хүнд олон талын гүн бат мэдлэг зайлшгүй чухал болохын тухай ярьж өгсөн гэнэ. Сурлагын хоцрогдлыг арилгах сурагчдыг сурах, юмыг мэдэх сонирхолтой болгон хүмүүжүүлэхэд чиглэгдсэн иж бүрэн арга хэмжээнүүд нь анги улирах явдлыг бараг арилгаж жилээс жилд сурагчдын мэдлэгийн чанарыг улам сайжруулж байна. Тэр сургуулийн хамт олон олсон амжилтандаа тайвшрахгүй сургалт хүмүүжлийн процессийг улам бүр боловсронгуй болгох үр ашигтай арга замыг эрж хайж байдаг ажээ.

Сурган хүмүүжүүлэгч. № 4/1981